

Банкны салбарын эргэн тойронд

01.02 – Гадаад валютын нөөц 3 тэрбум ам.долларт хүрлээ. mongolbank.mn

01.04 – Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайхан криптовалютын талаар мэдэгдэл гаргалаа. mongolbank.mn

01.08 – Капитрон банкны олон улсын картны жилийн хураамж болон заавал байлгах үлдэгдэл 50%-иар буурлаа. capitronbank.mn

01.10 – “Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах” аяны нээлтийн үйл ажиллагаа боллоо. mongolbank.mn

01.12 – Төв банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж баталлаа. mongolbank.mn

01.16 – ХХБ олон улсын төлбөрийн виза картууддаа payWave технологи нэвтрүүлэн, загвараа шинэчилж харилцагчиддаа хүргэж эхэллээ. tdbm.mn

Виза payWave карт нь зайнаас уншигдах технологи бүхий карт бөгөөд ПОС терминал дээр картыг физикал холболт үүсгэлгүйгээр зайнаас гүйлгээ хийх боломж олгодгоороо онцлогтой.

01.16 – ХААН Банк нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хэрэгжүүлж буй жилийн 12%-ийн хүүтэй хөнгөлөлттэй нөхцөл бүхий тэтгэврийн зээлийг дамжуулан олгохоор болж, НДЕГ-тай хамтран ажиллах гэрээг байгууллаа. khanbank.com

01.16 – Тогтвортой санхүүжилтийн “ТОС” холбоо үүсгэн байгуулагдлаа. mba.mn

01.18 – Голомт банк бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд хамгийн бага хүүтэй зээл олгоно. mba.mn

01.19 – Олон улсын үнэлгээний Moody's агентлаг Монгол Улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийн үнэлгээг Саа1 байсныг В3 болгон өсгөж, төлвийг “Тогтвортой” хэмээн үнэллээ. mongolbank.mn

01.23 – Голомт банк ажлын байр нэмэгдүүлэх зээл олгож байна. golomtbank.com

02.05 – ХХБ нь төлбөрийн картны мэдээллийн аюулгүй байдлын PCI DSS олон улсын стандартыг бүрэн хангаж, олон улсын PCI Security Standards Council -аас хүлээн зөвшөөрөгдсөн Аюулгүй байдлын үнэлээч ControlCase байгууллагаас PCI DSS 3.2 стандартын батламжаа гардан авлаа. tdbm.mn

02.06 – Капитрон банкны хэрэглээний зээлийн нөхцөл сайжирлаа. capitronbank.mn

02.12 – “Голомт Алтны форум” амжилттай зохион байгуулагдлаа. golomtbank.com

02.19 – Голомт банкны гүйцэтгэх захирал Ө.Ганзориг Монголын банкны холбооны ерөнхийлөгчөөр сонгогдлоо. mba.mn





02.20 – Банк хоорондын их дүнтэй гүйлгээний “RTGS – /Банксүлжээ/” системийн 2-р үеийн шинэчлэлийг нэвтрүүллээ. mongolbank.mn

02.20 – Банкны активын чанарын үнэлгээний үр дүнгийн талаар Монголбанк мэдээллэл хийлээ. mongolbank.mn

03.01 – Богд банк кредит картны бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүллээ. bogdbank.com

03.20 – Зээлийн хүүг бууруулах үндэсний стратегийг хэлэлцүүллээ. mongolbank.mn

Банкны салбарын гол үзүүлэлтүүд¹



Нийт актив = 28,9 их наяд төгрөг

Банкны салбарын нийт актив 2018 оны 1-р улиралд 28,9 их наяд төгрөг болж өмнөх улирлаас 0,1 их наяд төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 3,7 их наяд төгрөгөөр өслөө.

Ашиг = 58,7 тэрбум төгрөг

Банкуудын өөрийн хөрөнгө 2018 оны 1-р улирлын байдлаар 3,16 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2,3% өслөө. Харин банкны салбарын ашиг оны 1-р улирлын байдлаар 58,7 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеийн улирлын ашгаас 14,5 тэрбум төгрөгөөр дутуу байна.

Банкны нөөц = 2,5 их наяд төгрөг

Банкны нөөц 2018 оны 1-р улирлын байдлаар 2499 тэрбум төгрөгт хүрч өмнөх улирлаас 887 тэрбум төгрөг буюу 26,2 орчим хувиар буурлаа.

Чанаргүй зээл 9,1%

Нийт дотоодын зээл тогтмол өссөөр 2018 оны 1-р улирлын байдлаар 13,5 их наяд төгрөгт хүрээд байна. Харин чанаргүй зээлийн хэмжээ өндөр түвшинд хэвээр байна. 2018 оны 1-р улирлын байдлаар нийт чанаргүй зээл 1,22 их наяд төгрөг буюу нийт зээлийн 9,1%-ийг эзэлж байна.


¹ Эх сурвалж: Банкуудын нэгдсэн балансын гол үзүүлэлтүүд, Монголбанк

БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2018 он – I улирал


Ипотек = 4,25 их наяд төгрөг

Ипотекийн зээлийн үлдэгдэл 2018 оны 1-р улирлын байдлаар 4,25 их наяд төгрөг байна. Үүнээс 3,28 их наяд төгрөг нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл байна.




1\$=2395₮ 1¥=379₮

Монголбанкнаас зарласан ханшийн сарын дундаж хөдөлгөөнөөр 2018 оны 03-р сарын дундаж Ам.доллар-ын ханш 2395₮, Юань-ийн ханш 379₮ байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад Ам.долларын ханш 26₮-р буурсан, Юанийн ханш 23₮-р өссөн үзүүлэлт юм.




Харилцах+Хадгаламж=13,9 их наяд ₮

2018 оны 1-р улирлын байдлаар банкны салбарын нийт хадгаламжийн хэмжээ 10,0 их наяд төгрөг, харилцах 3,9 их наяд төгрөг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж 20,9%-иар, харилцах 38%-иар өссөн байна.



Пассив = 25,8 их наяд төгрөг

2018 оны 1-р улирлын байдлаар банкны салбарын нийт пассив 25,8 их наяд төгрөгт хүрлээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16,8%-иар өсжээ.



Онцлох² : Төв банк болон засгийн газрын үнэт цаас


Төв банкны үнэт цаас

Төв банкны үнэт цаас (ТБҮЦ) нь Монголбанкны мөнгөний бодлогын нээлттэй захын хэрэгсэл юм. 1 болон 4 долоо хоногтой ТБҮЦ-ийг банкуудад арилждаг. ТБҮЦ-ны хүү нь төв банкны бодлогын хүү юм. 2018 оны 3-р сарын байдлаар банкуудад 4,5 их наяд төгрөгийн ТБҮЦ байна. Банкууд дахь ТБҮЦ 2017 оны 1-р сард 0,4 их наяд төгрөг байснаас хойш тасралтгүй өссөөр байна.

Засгийн газрын үнэт цаас

Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ) гэдэгт нэг жил ба түүнээс богино хугацаатай богино хугацаат үнэт цаас болон 1 жилээс дээш хугацаатай засгийн газрын бонд орно. Засгийн газар нь төсвийн богино хугацааны орлого, зарлагын зөрүү болон зарим төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор үнэт цаас гаргадаг. 2017 оны 1-р сарын банкуудад 3,5 их наяд төгрөгийн ЗГҮЦ байгаа бол 2018 оны 3-р сард 2,1 их наяд төгрөг болж буурсан байна.

Банкууд дахь төв банк болон засгийн газрын үнэт цаас, их наяд төгрөг



² Эх сурвалж: Монголбанк

Банкуудын өрсөлдөөн

Арилжааны банкны үндсэн үүрэг нь мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй байгаа хэсгээс хөрөнгийг татаж, дутагдалтай байгаа хэсэгт шилжүүлэн, харилцагчдын итгэл дээр суурилсан санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа үзүүлэх, харилцагчдын хоорондын төлбөр тооцоог хийж гүйцэтгэх бөгөөд эцсийн зорилго нь санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан ашиг олох явдал билээ.

2018 оны 1-р улирлын байдлаар банкны салбарт нийт 14 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Монголбанкны тодорхойлсноор банкны системд нөлөө бүхий банкуудад Хаан банк, ХХБ, Голомт банк, Хасбанк, Төрийн банк, Улаанбаатар хотын банк гэсэн 6 банк багтаж байна. Эдгээр банкууд нь системийн 90-ээс дээш хувийг бүрдүүлж буй юм.

Арилжааны банкуудын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өөрчлөлт хөдөлгөөнийг харуулдаг мэдээллийн гол эх сурвалж бол банкуудын санхүүгийн тайлан юм. Банкуудын өрсөлдөөний тоймыг гаргахдаа санхүүгийн хураангуй тайланг ашиглан дараах үзүүлэлтүүдийг харьцуулсан болно. Үүнд:

- Актив
- Зээл
- Харилцах, хадгаламж
- Ашиг

Эдгээр үзүүлэлтээр арилжааны банкуудыг харьцуулахдаа активын хэмжээгээр нь Том-3 банк, Дунд-3 банк, бусад банкууд гэж ангилсан

Энэ удаагийн тайланд Капитал банкны мэдээлэл ороогүй болно. Мөн дараах банкуудын өрсөлдөөний тоймыг Капитал банкнаас бусад 13 банкны улирлын санхүүгийн тайланг ашиглаж тооцсон учир Монголбанкнаас гаргадаг нийт банкны салбарын үзүүлэлтээс ялгаатай гэдгийг анхаарна уу.



АКТИВ

БАНКУУД

ТОМ-3 БАНК

>3 их наяд төгрөг

Худалдаа хөгжлийн банк
Хаан банк
Голомт банк

ДУНД-3 БАНК

1-3 их наяд төгрөг

Хасбанк
Төрийн банк
Улаанбаатар хотын банк

БУСАД БАНКУУД

<1 их наяд төгрөг


Капитал банк
Чингис хаан банк
Капитрон банк
Үндэсний хөрөнгө оруулалтын банк
Ариг банк
Богд банк
Кредит банк
Тээвэр хөгжлийн банк

АКТИВ




Тайлант хугацаанд тайланд орсон 13 банкны нийт актив 28 их наяд төгрөг байна. Том-3 банк нийт активын 70,1%, Дунд-3 банк 23,4%, жижиг банкууд 6,2%-ийг эзэлж байна.

1 жилийн өмнөх мөн үетэй харьцуулахад Том-3 банкны актив 13%, Дунд-3 банкны актив 14%, жижиг банкуудын актив 46% тус бүр өсчээ.

Зах зээлд эзлэх хувь, активаар, 1У'18



Банкуудын активын хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлтийн хувь




ЗЭЭЛ




Тайлант хугацаанд тайланд орсон 13 банкны нийт зээл 13,2 их наяд төгрөг байна. Үүнээс 67%-г Том-3 банк, 26,5%-г Дунд-3 банк 6,5%-г жижиг банкууд бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банк 6%-иар, Дунд-3 банк 19%-иар, жижиг банкууд 49%-иар тус тус зээлийн хэмжээгээ нэмэгдүүлжээ. Харин нийт дүнгээр авч үзвэл банкуудын зээлийн хэмжээ 11,5% өсчээ.

Зах зээлд эзлэх хувь, 1У'18



Зээлийн хэмжээ, тэрбум төгрөг болон өсөлтийн хувиар




ХАДГАЛАМЖ БА ХАРИЛЦАХ




Тайлант хугацаанд тайланд орсон нийт 13 банкны харилцах ба хадгаламжийн хэмжээ 15,9 их наяд төгрөг байна. Үүнээс 70,1%-г Том-3 банк, 23,4%-г Дунд-3 банк, 6,5%-г жижиг банкууд эзэлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банк 24%-иар, Дунд-3 банк 18%-иар, жижиг банкууд 48%-иар тус бүр харилцах ба хадгаламжийн хэмжээгээ нэмэгдүүлжээ. Нийт дүнгээр нь авч үзвэл 24,1%-иар өсчээ.

Зах зээлд эзлэх хувь, 1У'18






Хадгаламж ба харилцахын хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлт



АШИГ

2018 оны 1-р улирлын байдлаар тайланд орсон 13 арилжааны банкуудын санхүүгийн тайлангийн нийлбэр дүнгээр банкууд нийт 89,4 тэрбум төгрөгийн ашигтай (татварын дараах дүн) ажиллажээ. Тайланд орсон 13 банкны хувьд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11,7 тэрбум төгрөгөөр илүү ашигтай ажилласан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банк 49%-иар ашгийн хэмжээгээ нэмэгдүүлсэн бол Дунд-3 банк 15 тэрбум, жижиг банкуудын ашиг 4,3 тэрбум төгрөгөөр багасжээ.

Банкуудын ашиг, алдагдал:



Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень 1Y'18, Монголбанк
2. Банкуудын нэгдсэн балансын гол үзүүлэлтүүд 1Y'18, Монголбанк
3. Монголбанкны ханшийн сарын дундаж хөдөлгөөн, Монголбанк
4. Арилжааны банкуудын улирлын санхүүгийн тайлан 1Y'18